



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 07 өдөр

Дугаар А/06

Өвт

Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэх заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "2021 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай" 2020 оны 2/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын 5 дугаар багийн нутагт Ерөнхий боловсролын сургуулийн 440 хүүхдийн хичээлийн байр барих зориулалтаар 1,3 га газрыг 60 жилийн хугацаатай газар эзэмших эрхийг олгосугай.

2. Дээрх газрыг эзэмших эрх авсан байгууллагатай эзэмших гэрээ байгуулан, гэрчилгээ олгож, газрын улсын бүртгэлд бүртгэн, хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (С.Ганхүлэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН